



НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Нийслэлийн орон сууцны бодлогын газар нь төрөөс гэр хорооллыг хөгжүүлэх, орон сууцны талаар баримтлах бодлого, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан иргэдийн амьдрах орчин, орон сууцны чанар, хүртээмж, дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх нэгдсэн бодлогоор хангана.

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслүүдийг хэрэгжүүлж, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангагдсан, орчны бохирдлыг бууруулсан орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.

Нийслэлийн гэр хорооллын газрыг дахин зохион байгуулж, бие даасан болон хэсэгчилсэн инженерийн дэд бүтцээр хангах, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй шинэ технологийг судалж, нэвтрүүлэх төслийн санал гаргана.

Хот суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд гадаад, дотоодын зээл, тусламжаар иргэдийн орлогод нийцсэн, шинэлэг технологи бүхий төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар нийслэлийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, ур чадвар, чадавхыг бэхжүүлэх, нийгмийн баталгааг хангах, мэргэшсэн хамт олон бүрдүүлнэ.

Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулж, тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулна.

Бид өдөр тутмын үйл ажиллагаандаа

- Байгууллагын үнэ цэн, нэр хүндийг дээшлүүлж, төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх;
- Иргэд, үйлчлүүлэгчид болон хамтран ажиллагч байгууллага, харилцагчдаа хүндэлж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагад хүндэтгэлтэй хандах;
- Хүнд суртал, авлигал, хээл хахууль, шан харамжаас ангид байх зарчмыг баримтлан ажиллана.